


Амьгүй шугам хоолой бол ил харагддаг аюулуудын нэг төрөл юм!

2022 оны 02-р сар



Ослын тойм?

Боловсруулах үйлдвэрийн талбайд 12 инчийн түүхий бодисын шугамтай холбогдсон 2 инчийн ус зайлуулах хоолойд рентген үзлэг хийгдсэн. Рентгенээр уг ус зайлуулах шугамын хөндлөн хэсэгт бодис хуримтлагдсан давхаргын доор гүнзгий ховилууд үүссэнийг тогтоосон. Улмаар бусад хэсэгт үзлэг хийхэд өөр олон цэгт ихээхэн хэмжээний дотоод зэврэлт илэрсэн. Эдгээр нь амьгүй шугам хоолойд түгжрэл үүсгэдэг зэврэлт бөгөөд тухайн үзлэгийн үр дүнд бодис хяналтгүй алдагдах ослоос сэргийлж чадсан.

Зураг 1 дээр үзүүлсэнтэй адил шугам хоолойн олон загвар нь амьгүй шугам хоолойн зэврэлт үүсэх нөхцлийг бүрдүүлдэг.

Зураг 1-ийн эх сурвалж: *Linkedin article by Mohammed Said MI & Hazard Identification of Dead Leg*

Та мэдэх үү?

- Амьгүй шугам хоолойн зэврэлт нь үйлдвэрийн болон ахуйн шугам хоолойн бүрэн бүтэн байдалд ноцтой аюул учруулдаг.
- Амьгүй шугам хоолойг анхны угсралтын үеийн угаалт, зайлуулалт, даралтын тестээс хойш дахин ашиглах шаардлагагүй байж болно. Тийм шугам хоолойг байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгөхийн өмнө салгаж авах нь зүйтэй.
- Зэврэлт үүсгэж болзошгүй материал агуулсан (бодистой холилдсон ус, хатуу материалын тунадас гэх мэт) амьгүй шугам хоолойг онцгой анзаарч, үзлэг хийж байх ёстой. H₂S зэрэг хийнүүд ч зэврэлт үүсгэж болзошгүй.
- Шугам хоолойд угаалт, зайлуулалт хийгдсэний дараа ч аюултай материал үлдэх боломжтой. Тийм шугам хоолойг нээхдээ хоосон бус шугам хоолой нээж буй мэт болгоомжтой хандах хэрэгтэй.

Та юу хийж болох вэ?

- Амьгүй шугам хоолойг олж тогтоох, цаашид шаардлагатай эсэхийг нь шийдэхийн тулд тогтмол үзлэг хий. Ашиглахгүй шугам хоолойг Өөрчлөлтийн Менежментийн журмын (MOC) дагуу салгаж авах нь зүйтэй.
- Үйлдвэрийн байгууламж амьгүй шугам хоолойг хянах хөтөлбөртэй байх хэрэгтэй. Тус хөтөлбөр нь дараах зүйлсийг багтаана:
 - Амьгүй шугам хоолойг тогтмол угаах хуваарь;
 - Зэврэлтийн зэргийн тооцоололд үндэслэсэн үзлэгийн төлөвлөгөө;
 - Үйлдвэрлэлийн аюул эрсдэл болон Өөрчлөлтийн Менежментийн (MOC) үнэлгээнд онцгой анхаарал хандуулах;

Амьгүй шугам хоолой “амьтай” байх боломжтой.

Ашиглагддаггүй шугам хоолойд зэврэлт үүсэхгүй гэж хэзээ ч бодож болохгүй.